УВС АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ АЛБАНЫ СУРГАЛТЫН ТАЙЛАН

2017.12.05 Улаангом

Нэг. Цагдаагийн газраас дотооддоо зохион явуулсан албаны сургалтын талаар:

Тус цагдаагийн газраас алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, албанаас зохион байгуулагдаж байгаа сургалтыг алба хаагчдын ажил мэргэжлийн онцлог, ажилласан жил, ур чадварт зохицсон шинэлэг байдлаар зохион байгуулах, албаны сургалтын чанар, үр дүнд ахиц гаргах зорилгоор "Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө"-г тус цагдаагийн газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 06-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар баталж, албаны сургалтыг сар бүрийн 1, 3 дугаар долоо хоногийн "Лхагва" гарагт 16.00 цагаас зохион байгуулан ажиллалаа.

Мөн цагдаагийн газрын төрөл мэргэжлийн тасаг, хэсгүүд дотооддоо зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулж сар бүрийн 2 дахь долоо хоногийн "Баасан" гарагт сургалт зохион байгуулж хэвшсэн.

Тус цагдаагийн газраас энэ онд зохион байгуулсан Цагдаагийн албаны тухай хуулийн чиглэлийн 18 удаагийн сургалтанд 1440 алба хаагч /*давхардсан тоогоор*/, Эрүү, Зөрчлийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн чиглэлийн 15 удаагийн сургалтанд 810 алба хаагч /*давхардсан тоогоор*/, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн чиглэлийн 7 удаагийн сургалтанд 501 алба хаагч /*давхардсан тоогоор*/, бусад хууль тогтоомжийн чиглэлийн 14 удаагийн сургалтанд 899 алба хаагч /*давхардсан тоогоор*/, албаны сургалтын чиглэлийн 90 удаагийн сургалтанд 3456 алба хаагч /*давхардсан тоогоо*р/ нийт 146 удаагийн сургалтанд 7106 /*давхардсан тоогоо*р/ алба хаагч хамрагдсан байна.

Түүнчлэн цагдаагийн газрын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан сургалтаас гадна "Авлигийн эсрэг хууль тогтоомжийг таниулах нь" "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг байгууллагын эрх бүхий албан тушаалтан 3 удаа 5 цагийн сургалт явуулсан байна.

Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын нэгдсэн төвөөс зохион явуулсан модулийн сургалтын талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/58 дугаар тушаалаар "Цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2017 оны сургалтын календарчилсан төлөвлөгөө"-г баталсан ба төлөвлөгөөний дагуу Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын нэгдсэн төвөөс 2017 онд зохион байгуулах сургалтын сэдэв, хөтөлбөрийг төв орон нутгийн цагдаагийн газар хэлтэст ирүүлсэн.

Сургалтын нэгдсэн төвөөс ирүүлсэн сургалтын сэдэв, эрэлт хэрэгцээ, шаардлагыг харгалзан тус цагдаагийн газраас Байгаль орчны журмын эсрэг гэмт хэргийн газрын үзлэг хийх, илрүүлэх арга тактик" сэдэвт сургалтанд 2, "Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа" сургалтад 1, "Дотоод аюулгүй байдлыг хангах ажиллагаа" сургалтад 1, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа" сургалтад 1, Цагдаагийн байгууллагын мэдээллийн сан, дүн бүртгэлийн системийн ойлголт, түүнийг ашиглах дадлага чадвар

ахиулах мэдлэг олгох сургалтанд 1, Мэдээлэл судалгааны ажилтны ур чадварыг дээшлүүлэх сургалтанд 1, “Мэргэшсэн хэрэг бүртгэгч-2” сэдэвт сургалтанд 2, “Зам тээврийн зөрчлийг шалгах ажиллагаа” сэдэвт сургалтанд 1, сургагч багшийн сургалтанд 2, нохойн төлөөлөгч бэлтгэх сургалтанд 1, уран зохицуулагчийн сургалтанд 1, гэмт хэрэгтэй тэмцэх албаны чиглэлээр зохион байгуулсан сургалтанд 3, эргүүлийн үйл ажиллагааны чиглэлийн сургалтанд 1 нийт 16 алба хаагчийг Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан сургалтанд хамруулан ажиллалаа.

Гурав: Цагдаагийн ерөнхий газрын албад, Хууль сахиулахын Их сургууль болон бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалтын талаар:

Тус цагдаагийн газар нь алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэднийг хөгжүүлэх, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хангах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын албад, Хууль сахиулахын их сургууль, бусад төрийн болон төрийн бус байгууллагаас энэ онд зохион байгуулсан сургалтад алба хаагчдыг хамруулан ажилласан.

Хууль зүйн яамнаас /*хуучин нэршлээр*/ Захиргааны ерөнхий хуулиар зохион байгуулсан сургалтанд 2, Нийтийн хэв журам хамгаалах албанаас зохион байгуулсан нийтийн хэв журам хамгаалах тасаг, хэсгийн дарга, хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч нарын сургалтанд 2, Хууль зүй дотоод хэргийн сайдын ОХУ-д хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу ОХУ-ын Краснодарын Их сургуульд “Терроризм болон бусад хүч хэрэглэсэн экстремизмын илэрлүүдтэй тэмцэх орчин үеийн арга хэлбэрүүд” сэдэвт 10 хоногийн сургалтанд 1, ЦЕГ-ын Хяналт, шалгалт үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс зохион байгуулсан “Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит, эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтанд 1, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас зохион байгуулсан сургалтанд 2, Эрүүл мэндийн яам, “Гал голомт” үндэсний хөдөлгөөнөөс зохион байгуулсан “ХДХВ-ын сайн дурын зөвлөгөө, шинжилгээ” сургалтанд 1, ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсээс зохион байгуулсан Сэтгэл зүйч нарын сургалтанд 1, Санхүү хангамжийн албанаас зохион байгуулсан баруун бүсийн эд хариуцагч нарын сургалтанд 3, Мэдээлэл холбооны инженерүүдийн сургалтанд 2, Нутаг академи” төрийн бус байгууллагын сургагч багш, доктор Б.Байгалмаагийн “Хувь хүний ёс зүй, харилцааны хандлага”, “Багийн ёс зүй, харилцааны хандлага”, “Сэтгэлгээний өөрчлөлт” сэдвүүдийн 6 цагийн сургалт 65, аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Б.Алтангийн “Төрийн алба хаагчдын харилцааны соёл” сэдэвт 1 цагийн сургалтанд 59, “Сайн тус” төрийн бус байгууллагын сургагч багш Б.Тогтохын “Харилцааны эерэг хандлага” сэдэвт 1 цагийн сургалтанд 61, Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Баримт бичгийн стандарт” сэдэвт сургалтанд 1, МУ-ын ШУТИСургууль, ЦЕГ болон Замын цагдаагийн албанаас хамтран зохион байгуулсан “Авто инженер” хөтөлбөрийн модулийн сургалтад 2, ЦЕГ болон Үндэсний статистикийн хороо, ХСИС-ийн хамтарсан “Статистикийн анхан шатны мэдлэг” олгох сургалтад 1, Цагдаагийн ерөнхий газраас зохион явуулсан цагдаагийн мэргэжлийн сургалтанд 4, аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан нятлан бодогч нарын мэргэшүүлсэн сургалтанд 2, эчнээ болон бакалаврын сургалтанд 8, Шихихутаг сургуулийн магистрийн сургалтанд 12 алба хаагчийг тус тус хамруулсан.

Мөн тус аймагт зохион байгуулагдсан гадаад хэлний сургалтанд 2, аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадваржуулах сургалтанд 2, Монголын мэргэшсэн нягтлан

бодогчдын институтын Увс аймаг дахь салбараас зохион байгуулсан нярав, эд хариуцагч нарыг мэргэшүүлэх сургалтанд 1 алба хаагчийг тус тус хамрууллаа.

Түүнчлэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчлийг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хуулийн 5 хоногийн сургалтанд цагдаагийн газрын 69 алба хаагчийг хамруулсан.

Дөрөв. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалтын талаар:

Тус цагдаагийн газраас энэ онд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран алба хаагчдын дунд дараах сургалтуудыг зохион байгуулж ажиллаа. Үүнд:

1. Авлигатай тэмцэх газрын мэргэжилтэнгүүд Увс аймагт ажиллах үеэр Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлэх, мэдэгдэл, тайлбар гаргах, бүртгэх, хадгалах сэдвээр 8 цагийн сургалт,
2. Аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэнээр "Чихрийн шижин" өвчний тухай ойлголт, илрэх шинж, урьдчилан сэргийлэх арга зам", "Элэгний гепатитын В вирүсийн халдвараас урьдчилан сэргийлье" сэдэвт сургалт,
3. Аймгийн онцгой байдлын албатай хамтран "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх" нь, "Гамшгаас хамгаалах тухай зарлан мэдээлэх", "Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж" сэдэвт сургалт,
4. Хүний эрхийн Үндэсний комиссын Увс аймаг дахь ахлах мэргэжилтэнтэй хамтран "Хүний эрхийн чиглэл"-ийн 2 удаагийн сургалт
5. Тус цагдаагийн газрын ахмад ажилтан бэлтгэл хошууч З.Лхагваагаар "Харилцааны соёл" сэдвээр 1 цагийн сургалт,
6. Хүүхэд, залуучууд гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран "Гэр бүлийн хүчирхийлэл" сэдэвт сургалт,
7. Аймгийн Ахмадын хороо болон Угсаатны холбоотой хамтран "Ургийн бичиг хөтлөх" сэдэвт 1 цагийн сургалт,
8. Аймгийн "Бат-Үржихүй" өрхийн эмнэлэгтэй хамтран" Эрчүүдийн эрүүл мэнд" сэдэвт 2 цагийн сургалт
9. "Нутаг академи" төрийн бус байгууллагын сургагч багш, доктор Б.Байгалмааг урьж "Хувь хүний ёс зүй, харилцааны хандлага", "Багийн ёс зүй, харилцааны хандлага", "Сэтгэлгээний өөрчлөлт" сэдвүүдээр 6 цагийн сургалт
10. "Сайн тус" төрийн бус байгууллагын сургагч багш Б.Тогтохоор "Харилцааны эерэг хандлага" сэдэвт 1 цагийн сургалт
11. Аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Эрүүл мэндийн газартай хамтран "ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт,
12. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Тэс, Зүүнхангай, Өндөрхангай, Наранбулаг сумын иргэдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулиар тус тус сургалтыг зохион байгуулаа.

Сургалтанд хамрагдсан алба хаагчдын сургалтын ирц, сургалтанд оролцож байгаа идэвхт Захиргааны удирдалгын тасгийн дарга тогтмол хяналт тавьж ажиллалаа.

Тав: Бусад

Тус цагдаагийн газраас энэ онд иргэд, олон нийтэд чиглэсэн 30 удаагийн сургалт зохион байгуулсан бөгөөд нийт 2850 иргэн хамрагдсан байна. Мөн алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, сургаж дадлагажуулах зэрэг сургалттай холбоотой үйл ажиллагаанд 7983200 төгрөг зарцуулжээ.

Мөн онд нийт 146 удаагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд урьд оны мөн үетэй харьцуулахад 2 нэгжээр буюу 1.3 хувиар өссөн байна.

Албаны сургалтын үйл ажиллагаа, чанар үр дүнд хяналт шинжилгээ хийсэн ба энэ онд зохион байгуулсан сургалт болон алба хаагчдыг сургалтанд хамруулсан байдлыг 84.5 буюу “Сайн” үнэлгээтэй үнэлсэн.

Зургаа . Цаашид дэвшүүлэх санал:

Тус цагдаагийн газраас цаашид сургалтын хүртээмж, чанар үр дүнг сайжруулахад чиглэгдсэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Сургалтыг бүсчилсэн байдлаар бүх албадын чиглэлээр зохион байгуулах.
2. Онлайн хэлбэрээр сургалтыг зохион байгуулж байх.
3. Сургалтын орчинг сайжруулж, шинэ техник хэрэгсэл нэвтрүүлэх.
4. Магистр, докторын зэрэгтэй алба хаагчдын судалгааг гаргаж тэднийг сургагч багшаар бэлтгэх зэрэг саналыг тус тус дэвшүүлж байна.

ТАЙЛАН БИЧСЭН: ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Н.МИШИГДОРЖ